



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар A/20

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 143 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм”- ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын үндсэн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тооллогын үйл ажиллагаанд шаардагдах төсвийг холбогдох зардлаас хууль, журмын дагуу гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Байгууллагын үндсэн эд хөрөнгийн тооллогыг журам, зааврын дагуу зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тооллогын комисс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА




Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газар-ын/ийн дарга-ын/ийн 2026
оны 05 дугаар сарын 26 өдрийн
А/20 дугаар тушаал-ын/ийн
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЭД ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн
	Ахлах нягтлан бодогч
	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан
	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер
	Архив, бичиг хэргийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга:	Нярав

Нийслэлийн Аялал жуулчлалын
газар-ын/ийн дарга-ын/ийн 2026
оны 05 дугаар сарын 26 өдрийн
А/20 дугаар тушаал-ын/ийн
хоёрдугаар хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЭД ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

2026 оны 05 дугаар сарын 21

Улаанбаатар хот

№	Зардалын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1.	QR хэвлэгч төхөөрөмж	1ш	800,000	800,000
2.	QR хэвлэгч төхөөрөмжний наадаг цаас	3ш	16,000	48,000
Нийт дүн				848,000

